



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 05 өдөр

Дугаар А/237

Бат-Өлзий сум

Шууд гэрээ байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг, 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны төсвийн тодотгол батлах тухай” 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 22/01 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ажлын хэсгийн 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 01 дүгээр хурлын шийдвэрийг үндэслэн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Бизнес хөгжлийн төвийн түрээсийн байрны засварын ажлыг Иргэн Т.Мөнхбаяртай шууд худалдан авах гэрээгээр гүйцэтгүүлсүгэй.

2 Иргэн Т.Мөнхбаяртай гэрээ байгуулж, Бизнес хөгжлийн төвийн түрээсийн байрны засварын ажилд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3 Иргэн Т.Мөнхбаяртай ажилд шаардагдах 10,000,000 (арван сая) төгрөгийг гэрээнд заасны дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн бусад хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Б.Пүрэвсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Н.ОРХОНТУУЛ

